

## НИЙТЛЭЛ, ТЭМДЭГЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ

**«ХКН-ЫН 60 ЖИЛ, ТҮҮХЭН ЗАМНАЛ, СУРГАМЖ»  
СЭДЭВТ ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ  
БАГА ХУРАЛ**

ЗХУ-ын ШУА-ийн Алс Дорнодын хүрээлэнгээс эрхлэн Москва хотноо 1981 оны дөрөвдүгээр сарын 7-ноос 9-ний өдрүүдэд «ХКН-ын 60 жил, түүхэн замнал сургамж» гэсэн сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг ХКН-ын 60 жилийн ойд зориулан зохион явуулав. Бага хуралд ЗХУ, БНБАУ, БНСВУ, БНАГУ, БНКУ, БНМАУ, БНПАУ, БНСЧСУ -ын Шинжлах Ухааны Академийн эрдэм шинжилгээний холбогдох хүрээлэнгүүдийн дорно дахинч эрдэмтэд, хятад судлаач нар оролцов.

Бага хурлын нээлтийн ажиллагаанд ЗХУКН-ын Төв Хорооны хэлтсийн нэгдүгээр орлогч эрхлэгч, түүхийн ухааны доктор О.Б.Рахманин, ЗХУ-ын ШУА-ийн дэд ерөнхийлөгч, академич П.Н.Федосеев болон бусад эрдэмтэд оролцож үг хэлэв. Тус хуралд ЗХУ-ын ШУА-ийн Алс Дорнодын хүрээлэнгийн захирал, сурвалжлагч гишүүн М.И.Сладковский «ХКН-ын үүсэл, үйл ажиллагаанд пролетарийн интернационализмын ач холбогдол» гэсэн томоохон илтгэл тавилаа.

Бага хурал «Улс төр, үзэл суртлын асуудал», «Нийгэм-эдийн засгийн асуудал» гэсэн хоёр секцээр хуралдаж зөвлөлтийн болон социалист бусад орнуудын эрдэмтдийн 60 гаруй илтгэл, мэдээллийг сонсов. Эдгээр орнуудын эрдэмтэд, судлаач нар ХКН-ын болон Хятад дахь хувьсгалт хөдөлгөөний судалгааны талаар багагүй ажил хийснийг тус эрдэм шинжилгээний бага хурал харуулав.

ЗХУКН-ын улс төр, зохион байгуулалтын тусламж, олон улсын нийт коммунист хөдөлгөөний дэмжлэг, эв санааны нэгдэл нь ХКН-ыг хятадын нийгмийн хувьсгалт хүчний манлай болгох, үндсэрхэх хандлагыг гэтлэн давах, БНХАУ-ыг социалист байгуулалтын замд шилжүүлэхэд тус дөхөм үзүүлсэн юм гэж илтгэгчид тэмдэглэлээ.

Гэвч ХКН-ын удирдлага нь 50-иад оны эцсээр дотоодын болон олон улсын бодлогод социализмын зарчмыг мушгин гуйвуулсан Мао Зэдуны жижиг хөрөнгөтний үндсэрхэх бүлэглэлийн мэдэлд төвлөрч байв. Энэ нь олон улсын коммунист хөдөлгөөнөөс ХКН-ын холбоог таслахад хүргэж, Хятад улсын хөгжлийг милитарист улс байгуулах замаар чиглүүлсэн юм гэж илтгэлүүдэд дурдсан байна.

Бага хурал ХКН-ын түүх, хятадын улс төрийн амьдралд ХКН үүсч хөгжсөн өвөрмөц онцлог, түүний бүхий л үе шатанд марксист интернационалч ба жижиг хөрөнгөтний үндсэрхэх хоёр чиг шугам тэмцэлдэж байсныг шинжилгээний үндэстэйгээр батлан харууллаа.

ХКН-ын маоист удирдлага марксизм-ленинизмийн зарчмаас няцсан нь Хятад улсыг гүн гүнзгий хямралд оруулав. Тийм чиг бодлого хятадын эрд түмний язгуур эрх ашигт харшилж байна гэж эрдэмтэд хэлсэн үгэндээ тэмдэглэлээ. ХКН анх чухамхүү марксист-ленинист сургаалыг удирдлага болгосны үр дүнд хятадын хувьсгалыг ялалтанд хүргэн социализм байгуулалтын замд оруулсан хэдий боловч Маогийнхан ХКН-ын үйл ажиллагааны интернационалч хэлхээ холбоог сулруулж, хувьсгалын өр-

нөлт хийгээд социалист байгуулалтанд ажилчин ангийн манлайллыг алдахад хүргэсэн нь баримтаар нотлогдож байна.

Эрдэмтэд Зөвлөлт, Хятадын харилцааны талаар хэлсэн үгэндээ: «ЗХУ, БНХАУ-тай сөргөлцөх шалтаг эрээгүй, эрэх ч үгүй, хятадтай сайн хөршийн харилцаатай байхад урьдын нэгэн адил бэлэн байна.

Хятадын ард түмнийг хүндэтгэн эв найрапдалтай байх зөвлөлтийн хүмүүсийн сэтгэл хувиршгүй хэвээр байгаагийн нэг адил БНХАУ-тай харилцаагаа хэвийн болгоход чиглэсэн зөвлөлтийн үр бүтээлтэй санал хүчин төгөлдөр хэвээр байна» гэж ЗХУКН-ын XXVI их хурал дээр онцлон тэмдэглэснийг дурдав.

ХКН нь Маогийн уламжлалаас бүрэн дүүрэн татгалзаж, ХКН-ын ажилчин ангийн удирдан манлайлах ролийг сэргээж империализмыг эсэргүүцсэн ардчилсан хүчин болон дэлхийн коммунист хөдөлгөөнтэй хамгийн ойр дотно хэлхээ холбоо тогтоосон цагт өнөөгийн хүнд байдлаас гарч болох нь тодорхой юм гэж бага хуралд үг хэлсэн эрдэмтэд тэмдэглэв.

**Б. Батболд**